5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		96,660.42
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	22
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	12
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	5	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	22
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	7
650010	Гэрээт ажилтан	3	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,457.23	11,087.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,457.23	11,087.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,263.23	11,087.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,628.00	-
210101	Үндсэн цалин	310.00	
210104	Урамшуулал	52,318.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210.00	-
210301	Гэрэл, цахилгаан	210.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	5,317.63	1,963.50

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	-	103.50
210402	Тээвэр, шатахуун	5,317.63	1,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	330.00
2105	Нормативт зардал	13,346.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,112.00	
210502	Хоол, хүнс	1,234.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000.00	
210604	Урсгал засвар	1,000.00	
2107	Томилолт, зочны зардал	-	160.00
210702	Дотоод албан томилолт		160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,556.60	8,964.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,009.55	8,964.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,547.05	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	194.00	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	194.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	194.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,457.23	11,087.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,457.23	11,087.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	160.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,498.26	873.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,958.97	5,054.04
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “Хуулиар хүлээлгэсэн нийтлэг бүрэн эрх үүргээ хэрэгжүүлэхийн төлөө бүх хүчин чадал, ур чадвар, хуримтлуулсан туршлагаа дайчлан чин шударгаар ажиллан, тэргүүний эвсэг, шилдэг хамт олон бүрдүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгын хүрээнд: “Иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, нь хуулиа дээдэлсэн, төрийн үйлчилгээ нь нээлттэй, шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй, ёс зүйтэй, ажил хэрэгч, иргэдийн санал хүсэлтийг хүндэтгэсэн байх зэрэг тусгасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Алтанцөгц сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас Алтанцөгц сумын төсөвт байгууллагуудын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,913.7 сая төгрөгөөр буюу 72.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51,329.6	117,238.2	65,908.6
Авлага	309,562.3	152,639.4	(156,922.9)
Бараа материал	176,768.6	31,037.7	(145,730.9)
Үндсэн хөрөнгө	4,859,109.7	1,182,183.2	(3,676,926.5)
Нийт хөрөнгө	5,396,770.2	1,483,098.5	(3,913,671.7)
Өр төлбөр	44,029.9	-	(44,029.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,352,740.2	1,483,098.5	(3,869,641.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,396,770.2	1,483,098.5	(3,913,671.7)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 65.9 сая төгрөгөөр өссөн нь төсөл сангийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 156.9 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 0.1 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 73.8 сая, зээлийн хүүгийн авлага 2.8 сая, сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 55.8 сая төгрөгөөр тус тус буурсан дүнтэй байна.

Бараа материалын данс 145.7 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө данс 3,676.9 сая төгрөгөөр тус тус буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр дансны оны эхний 44.2 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж, оны эцэст өглөггүй гарсан байна.

Тайлант онд -3,810.7 сая төгрөгийн үр дүнтэй гарсантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 3,869.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Алтанцөгц сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх **4 хөтөлбөрт** зориулан 1,076.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 835.4 сая төгрөгийг урсгал зардалд, 38.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 860.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 146.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 70.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтанцөгц сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,038.8 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 965.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 146.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 73.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Батлагдсан төсөв нийт дүнгээрээ 37.9 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан ба үүнээс орон нутгийн төсвөөс 15.8 сая төгрөгийн төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/-гийн 11.3 сая төгрөгөөр тасарсан, өмнөх оны ОНХС-гаас иргэдэд олгосон тэжээл, зураг төсвийн үнэ зэргээс 14.4 сая төгрөгийг оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 967.5 сая төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн тасарсан орлоготой холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 73.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Үүний 58.6 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Алтанцөгц сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 222.9 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 95 дугаар тодотголоор 227.2 сая төгрөгөөр буюу 4.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 46 дугаар хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 227.2 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 228.6 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 1.4 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
-----------------	-------------------	------------------	---------------------------------	----------------------------

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

I.Татварын орлого	222,401.7	208,050.8	-14,350.9	91.0
II.Татварын бус орлого	4,800.0	20,535.9	15,735.9	9.0
Нийт дүн	227,201.7	228,586.7	1,385.0	100.0

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос цалин хөлсний орлогоос 10.6 сая, үйл ажиллагааны орлогын албан татвар 23.6 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 6.5 сая, үл хөдлөх хөрөнгийн татвар 1.0 сая, бууны албан татвар 1.3 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамжаас 0.2 сая, хог хаягдлын хураамж 7.4 сая, ойн нөөцийн төлбөр 1.7 сая, газрын төлбөр 12.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлого төлөвлөгөө давж биелэгдэхэд хөрөнгө борлуулсны орлогоос 2.8 сая, улсын тэмдэгтийн хураамж 2.8 сая, хүү торгуулийн орлого 8.5 сая төгрөгөөр давж биелэгдэн, орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй малд ногдуулах албан татвар 9.5 сая, агнуурын нөөцийн төлбөрөөс 35.5 сая, ус ашигласны төлбөр 0.2 сая, бусад нэр заагдаагүй орлогоос 7.2 сая төгрөгийн орлого оруулсан нь орон нутгийн орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Сумын орон нутгийн орлогын биелэлт хангалтгүй байгаа нь зарим орлогын төлөвлөгөө үндэслэлгүй өндөр төлөвлөгдсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 25.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 228.6 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 15.8 сая төгрөгийн санхүүжилтийн төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 20.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар: /мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	53,155.2	53,155.2	-
2	Сумын ЗДТГ	408,172.5	397,415.1	10,757.4
3	Ерөнхий боловсролын сургууль	255,775.9	241,185.1	14,590.8
5	Хүүхдийн цэцэрлэг	72,191.3	71,967.6	223.7
8	Соёлын төв	41,800.2	41,301.2	499.0
9	Эрүүл мэндийн төв	29,229.9	28,749.1	480.8
10	ОНХСан	146,429.1	146,429.2	(0.1)
11	СХС	70,000.0	58,628.7	11,371.3
12	ОНХСан			-
	Нийт дүн	1,076,754.1	1,038,831.2	37,922.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд сумын төсөвт байгууллагуудад төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжид 5.0 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 0.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 0.9 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 5.1 сая төгрөгийн нийт 11.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 2.0 сая, томилолтын зардалд 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 9.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 03-ны өдрийн 1/30 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,850.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд дараах зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 0.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15.3 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 69.3 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 20.3 сая, хөрөнгийн зардлыг 3.9 сая төгрөгөөр нийт 109.3 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад ОНХС-ийн төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрүүдийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байхаар аудитын зөвлөмж өгөгдсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгаж ажиллах талаар 1 заалттай зөвлөмж өгөгдсөний биелэгдээгүй. Учир нь дээрх 2 санг хариуцсан 1 нягтлан бодогч өмнөх онуудаас ажиллаж ирсэнтэй холбоотой зөвлөмж биелэгдээгүй байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0			
Нийт дүн	1	0			

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Алтанцөгц сумын Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 3 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй, акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой 2 заалттай зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар	1									1	
2	Алтанцөгц сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал		-	-	-	-	-	-	-	-		
3	Алтанцөгц сумын ОНХСан	1	-	-	-	-	-	-	-	-	1	
4	Алтанцөгц сумын Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-	-	-	-	-	-		
Нийт дүн		2	-	-	-	-	-	-	-	-	2	-

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой 1 заалттай зөвлөмж өгөгдсөн байна.

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд ОНХС-ийн төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрүүдийг илэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Алтанцөгц сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудасны мэдээллийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрүүдийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	1						1	
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								